



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн үнэлгээ
тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дахь заалт, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.4 дахь заалт, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн 2025-2026 оны хичээлийн жилд шинээр элссэн суралцагчдын сургалтын төлбөрийг 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр, 2024-2025 оны хичээлийн жилд элссэн суралцагчдын сургалтын төлбөрийг 5,400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр, 2023-2024 оны хичээлийн жилд элссэн суралцагчдын сургалтын төлбөрийг 4,900,000 (дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгөөр, 2022-2023 хичээлийн жилд элссэн болон түүнээс өмнө элссэн суралцагчдын сургалтын төлбөрийг 4,140,000 (дөрвөн сая нэг зуун дөчин мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захирал (Д.Дулмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Л. ТӨГСБАЯР